



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар A/38

Улаанбаатар хот

“Улаанбаатар-2019” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/480 дугаар захирамж, Газрын дүрмийн 2.5.3, 3.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг нэг цэгээс хэрэглэгчидтэй уулзуулах, аялагч амрагчдыг нэг дороос аяллын талаар бүх мэдээ мэдээлэл авах боломжийг олгох зорилгоор “Улаанбаатар-2019” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэнг 2019 оны 05 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Мишээл экспо төвд зохион байгуулсугай.

2. “Улаанбаатар-2019” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэнг зохион байгуулахад энэ тушаалын хавсралтад заасан 12 334 000 /Арван хоёр сая гурван зуун гучин дөрвөн мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д зөвшөөрсүгэй.

3. “Улаанбаатар-2019” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэнг зохион байгуулахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс /В.Батчимэг/-т, Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллахыг Мэдээлэл, сурталчилгааны хэлтэс /М.Болортуяа/-т тус тус даалгасугай.

ДАРГА *Д.Батсүх* Д.БАТСҮХ



1150500210

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 05
сарын 21 өдрийн А/38 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5234325 СБТ-8936 1118263502

“УЛААНБААТАР-2019” ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ҮЗЭСГЭЛЭНГИЙН ТӨСВИЙН ЗАДАРГАА

2019 оны 05 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Тайз засал /лед дэлгэц, хөгжмийн түрээс 3 өдөр/	3	1 500 000	4 500 000
2	Сурталчилгааны шторк бэлтгэх	Багц /30 сек/	1 500 000	1 500 000
3	Хөтлөгч 3 өдөр	3	800 000	2 400 000
4	Хөмсгөн хаяг /5x0.3м хэмжээтэй/	105 ш	9000	945 000
5	Гадна талбайд байрлуулах хөтөлбөр хэвлүүлэх /хөлтэй баннер/	6	150 000	900 000
6	Гадна самбарт анонс хэвлүүлэх, тогтоох байрлуулах Жанжин Д.Сүхбаатарын талбайн урьд талын самбарт	11:11м2 121м2	9000	1 089 000
7	“Цайны зам” олон улсын аялал жуулчлалын холбоо болон Нийслэлийн Аялал жуулчлалын газрын стэндний тохижилт	18 м2	1 000 000	1 000 000
Нийт			12 334 00	